

ХӨНГӨН АТЛЕТИК



МОНГОЛЫН ХӨНГӨН
АТЛЕТИКИЙН ХОЛБОО

Хөнгөн атлетик нь эртнээс нааш хүний суурь хөдөлгөөнүүд болох гүйх, харайх, шидэх зэргийг спортын тогтсон замд оруулсан бөгөөд өргөн цар хүрээ бүхий дүрэмтэй ба тухайн бие хүний ур чадварыг яг тодорхой харьцуулах болон хэмждэг олон төрөлт спорт юм.

Хөнгөн атлетик нь бие даасан спортын төрөл юм. Хөнгөн атлетикийн тэмцээнд оролцож буй тамирчид нь хамгийн өндөр үзүүлэлт буюу амжилтыг гаргаж байж, ялалтад эсвэл шагналт байрт шалгарна. Мөн түүнчлэн хэн нэгний тогтоосон дээд амжилт, эсвэл өөрийн дээд амжилтыг эвдэх нь тамирчдын өмнөө тавьсан зорилго ч байж бас болдог.

Хөнгөн атлетикийн тамирчдын гаргасан амжилтыг хэмжих, түүнийг нь хүлээн зөвшөөрөх дүрэм, нөхцлийг олон улсын тэмцээний дүрмээр нарийн тодорхой зааж өгсөн байх учир тухайн тамирчны амжилтыг дэлхий даяар харьцуулан үзэх боломжтой юм.

Атлетик гэх үг нь эртний грек хэлний $\alpha\theta\lambda\eta\tau\acute{\iota}\varsigma$ атлētēs буюу монголоор “тэмцээний өрсөлдөгч” гэсэн утгатай үг юм. Хөнгөн атлетикаас гадна атлетик гэх нэршил нь мөн хүнд атлетикч болон хүчний тамирчинд бас хэрэглэгдэнэ

Хөнгөн атлетикийн төрлүүд нь гүйлт, харайлт, шидэлт гэсэн бүлэгт хуваагддаг ба олон төрөлт нь олон төрлөөс бүрдэх боловч дээрх гурван төрөл үүнд заавал багтдаг.

МОНГОЛ УЛСАД ХХӨНГӨН АТЛЕТИКИЙН СПОРТ ҮҮСЭЖ ХӨГЖСӨН НЬ

1921 оны Хувьсгалаас өмнө хөнгөн атлетикийн спорт тоймлосон чиглэлтэй хөгжиж байгаагүй ч мориноос хурдан гүйдэг, ширэн оосортой чулуу /дүүгүүртэй төстэй/ шидэж цэц мэргээ соридог хуруу дарам цөөн хүмүүс байжээ.

Тэдний тухай ам дамжин яригдаж ирсэн зарим жишээг дурдахад XIX зууны сүүл XX зууны эхэн /1862-

1964 он/ үед хуучин Түшээтхан аймгийн Боржигон цэцэн вангийн хошууны /одоогийн Төв аймгийн Баянжаргалан сум/ нутагт Мижидийн Тавхай

нутгийнхны нэрлэснээр “Гялан Тавхай” хэмээх хүн амьдарч байжээ.Тавхайтай нутаг нэгт үе чацуу Данайн Гэндэн, Боор Яринпил гэдэг гайхамшигтай хурдан хүмүүс байсан ч Тавхай хурдны хувьд гарамгай, хол зайд бусдаасаа илүү аж. Гялан Тавхай яда рсан зарим нөхөддөө явганаар улаа нэхэж яаруу ажлаар дүрэмддэг элч нарыг ямар ч гэ сэн зам хаадаг, гурван өртөө газрыг гудиггүйхэн нэхчихдэг нэгэн байв. Элчийн гурав д ахь морь эцэхийн туйл хүрдэг нь Тавхайн тэсвэртэй хурд сүүлдээ нэмэгддэгийнх юм гэсэн домог яриа Монголчууд гүйлтийн ямар ч зайд гүйх чадвартайн нотолгоо юм.

Автономит Монгол улс 1911 онд байгуулагдаж орос цэргийн сургагч нарыг урин ирүү лж монгол цэргийн дарга нарыг бартаат замаар гүйх, уртад харайх, чулуу алсад шидэх зэрэгт сургаж, ийм журмаар дайчдын бие бялдрыг чийрэгжүүлэн хөнгөн атлетикийн за рим төрөл хөгжих эхлэл суурь тавигдсан байна

1930аад оны дунд үеэс хөнгөн атлетикийн сонгомол зай, төрөл дэлгэрч эхэлсэн ч нийтлэг хөгжлийг хараахан олоогүй учир Монгол ардын хувьсгалт армийн дайчид 1 000 м

т гүйх уртад байрнаас болон гүйлтээс харайх, гранат шидэх төрлөөр хичээллэж байв.

1945 онд спорт клуб “Хүч”,

“Хилчин” байгуулагдаж хөнгөн атлетикийн уралдаан тэмцээн зохиож, үзүүлэх тогло лт хийдэг байсан нь уг спортыг өргөн олонд сурталчлахад ихээхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Мөн 1946 онд Улаанбаатар хотод спортын сайн дурын Ард, Хөдөлмөр, Соёл, Цэрэг зэ рэг нийгэмлэгүүд байгуулагдан үйл ажиллагаагаа явуулсанаар хөнгөн атлетикийн спор тыг хөгжүүлэхэд томоохон хувь нэмэр оруулжээ. Улаанбаатар хотын Биеийн тамир спортыг хороонд 1976 онд бүтцийн өөрчлөлт хийж хөнгөн атлетикийн төрлийг хари уцсан зааварлагчтай болж хөнгөн атлетикийн төрлөөр Улаанбаатар хотын аварга шалг аруулах тэмцээнийг тогтмол явуулах болжээ.

БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1947 оны 4 сарын 25- ны өдрийн шийдвэрээр Биеийн тамир, спортын улсын нэгдсэн бодлогыг эрхлэх төв байгууллага БНМАУ-ын СнЗ- ийн дэргэдэх Биеийн тамир, спортын хэргийг эрхлэх хороо байгуулагдаж улмаар 1960 онд Монголын Биеийн тамир спорт эвлэлийн төв зөвлөл /МБТСЭ/ нэртэй олон нийт ийн байгууллага болон өргөжив.

Биеийн тамир спортын төв байгууллага бий болсноор хөнгөн атлетикийн спорт хүн амын нийтлэг хүрээллийг олж 1958 оноос ерөнхий боловсролын болон тусгай дунд, их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт заавал орох хичээлд ийн хичээл орох болов.

Хөдөлмөр батлан хамгаалахад бэлэн /ХБХБ/ тэмдгийн I,II,III ангиллын нормативт 100м,1500мийн гүйлт, урт, өндрийн харайлт, бөөрөнцөг түлхэлтийн төрөл орж спортын сайн дурын нийгэмлэгүүдийн дэргэд хөнгөн атлетикийн секц, бүлгэм тогтмол хичээллэдэг болов.

Хөнгөн атлетикийн уралдаан тэмцээний тогтолцоо үүссэн нь

Ардын хувьсгалын 18 жилийн ойгоор зохиогдсон улсын чанартай уралдаан тэмцээнийг эс өгүүлвэл 1940-өөд оны дунд үеийг хүртэл зөвхөн аймаг, хотын төвд уралдаан тэмцээн явагддаг байжээ.

3000 залуусын жагсаал, гимнастикийн тоглолтоор эхэлсэн улсын анхдугаар спартакиад 1946 оны 7 сарын 11-нд АХ-ын 25 жилийн ойн баяраар хөнгөн атлетикийн уралдаан тэмцээн 100м, 300м, 1000м, 4х100м, 4х200м-ийн буухиа гүйлт, урт өндрийн харайлт, зээрэнцэг, бөөрөнцөг, гранат шидэлтийн төрлөөр явагдаж 232 тамирчин оролцон үзэгч олны сонирхлыг ихэд татсан сайхан арга хэмжээ болсон байна.

Спартакиадын эмэгтэйчүүдийн 100м-т 42, уртын харайлтанд 18, өндрийн харайлтанд 18, эрэтэйчүүдийн 1000м-т 20, 3000м-т 28, уртын харайлтанд 20, өндрийн харайлтанд 19 тамирчин оролцжээ.

1946-1954 оны АХ-ын ойн баяраар зохиогдсон спартакиад нийтийн биеийн тамирын хөдөлгөөний өрнөлт тамирчдын ур чадварын том үзлэг, ард түмний спортын томоохон баяр болж байв.

Спартакиадын арга хэмжээ нь спортыг төв, орон нутагт хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

1957 онд улсын аварга шалгаруулах тэмцээн, 1959 онд нийслэл хотын өвлийн аварга шалгаруулах уралдаан тэмцээн зохиож байсан нь манай оронд бүтэн жилийн сургалт дасгалжуулалтыг явуулах зайлшгүй нөхцөлийг бий болгосон.

Үүний үр нөлөөгөөр зэрэг, цолтой тамирчин, хичээллэгчдийн тоо байнга өсч нэгэн үе 1990 оны улсын статистикийн дүн бүртгэлээр хөнгөн атлетикаар хичээллэгчид 98878, зэрэг уолтой тамирчид 6403-т хүрч байсан удаатай.

1949 онд анх удаа хилийн дээс алхаж албан ёсны олон улсын тэмцээнд оролцсон хүн бол олон талт авьяаслаг тамирчин Д.Агваандугар байлаа. Тэрээр 1949 онд Будапешт хотноо Дэлхийн Залуучууд Оюутны их наадамд 100 м гүйлт, урт, өндрийн харайлтын төрөлд амжилттай оролцож, О.Цэрмаа 800м-

ийн зайд II байр эзэлж олон улсын тэмцээнээс анхны мөнгөн медалийг эх орондоо авчирсан байна.

Казакстан, Киргиз, Туркмен, Москва, БНАСАУ, Өвөрмонгол, Буриад улсын баг т амирчидтай уулзалт тэмцээнийг 1958, 1960, 1961, 1972, 1979, 1986, 1987, 1991 онд тус тус зохиож амжилт ур чадвараа ахиулж байжээ.

1977 онд Будапештэд зохиогдсон Үйлдвэр хоршооллын олон улсын спартикиад ад Б.Энхбаатар уртын харайлтад алтан медаль, 1977 онд БНАГУ-ын Халле хотод зохиогдсон “Владимир Церпик”-ийн тэмцээнд Б.Батцэнгэл 800 м-т хүрэл медаль,
1978 оны 6 сард Софи хотод явагдсан “Народна Младеш” сонины нэрэмжит, олон улс ын “Гран при” тэмцээнээс С.Сарантуяа 1500м-т алтан медаль, 10000м-т Б.Мөнхдалай хүрэл медаль хүртэж, 1987 онд БНПАУ-ын Зелоногур хотод болсон олон улсын тэмцээнээс Ц.Одонбаяр 100м-ийн зайд мөнгөн медаль,
2003 онд Японы Тояама хотод болсон олон улсын марафон гүйлтийн 21 км-ийн 0975 м-ийн зайд Б.Сэр-Од, Б.Батцэцэг нар хүрэл медаль,
2003 онд Бээижн хотноо болсон олон улсын “Екедин буухиа” тэмцээний 10000м-ийн зайд хүрэл медаль, 2004 онд Саул хотноо болсон олон улсын наадмын 1500м-ийн зайд Л.Отгонбаяр мөнгөн медаль, 5000м-ийн изайд алтан медаль, Б.Сэр-Од 5000м, 10000м-ийн зайд алтан медаль хүртсэн.